



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар АА/15

Улаанбаатар хот

Арванхоёрдугаар сарын ур чадварын нэмэгдэл  
олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4; Төсвийн тухай хуулийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дугаар тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг хавсралт ёсоор тогтоон олгосугай.
2. Албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/, Орон нутаг дахь газрын дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.
3. Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгосон талаар албан хаагчдад мэдээлэл бэлтгэн хүргүүлэхийг Тамгын газар /Д.Давааням/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000001759